



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

395.	Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 90	3171
------	--	-----------	------

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

396.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 61	3172
397.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 62	3172
398.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 63	3173
399.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 64	3173
400.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 65	3174
401.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 66	3174
402.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 67	3175
403.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 68	3175

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

404.	Журам батлах тухай	Дугаар 172	3176
405.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 192	3188



402'	ҮИР, ЗИЛСЧИЛЭС ПЯРАЛБЕНО ДООБЕИ ҮИР, ПЯРАЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* 1А5	3188
404'	ИЙСЭДЭГ ҢОЛД_ ОЯ ҮЭГЭ (* ОЯ ДООБЭДЭГ	ҠРДБ* 1А5	311Р
403'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р8	3112
405'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р1	3112
401'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* РР	3114
400'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р2	3114
3дд'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р4	3113
3д8'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р3	3113
3д1'	ЕКК109 ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р5	3115
3дР'	ЕКК109 ДАРАБЕНО' ДООНОДБС ДУИЛБЕНО ДООБЕИ	ҠРДБ* Р1	3115
3д2'	ИЙСЭДЭГ ҢОЛД_ ОЯ ҮЭРДЭГЭЛГЭК1 ҮИС ҮЭЛ11 ( ДЭГҮ НОЛДБС О ВИЛИРОКС ҠО ҢОЙГЭСЧЛГЭРС ҢОЛДОЛБЕНО ДООБЕИ ИЙСЭДЭГ ҢОЛД_ ОЯ ҮЭГЭ НОЛБС ОЯ ДООБЭДЭГ	ҠРДБ* Д0	3111

ᠮᠤᠰᠤᠨ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 11 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар  
хот

### Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут, Жаргалтулгын Эрдэнэбат нарыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Лхагвын Мөнхбаатар нарыг Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

Үежиг Нолёж 09 Дарло) Т  
 Монгодох Е010\_09  
 5' Лис Дөөрөөдөг | ррп0лөөсээ Е00\_ Ес9 Елнээ Дөдй0 Монгодохуки.  
 Нолёж 0 КээКя гие\* До\_ До\_ ррр0лөөсөдөй.  
 Г-өөрөг 119 Монгодохукино\* Ие\* | Кил0 ФоллөөрВиллээ 09 КилКил 09 ДөвН  
 Нолёж 0' Монгодох Е010\_09 Үежиг Нолёж 09 КээКя9 Соодор\* 09 ДөвНгилнн.Т'  
 11р0лөөд0) Т 119 Едөөрлрр0 Ие\* | 11111' Дөвн9 ФоллөөрВиллээ 09 ДөвН  
 1' Монгодох Е010\_09 Үежиг Нолёж 09 КээКя9 Дөвнф 119 ррр0лөөд0'  
 Монгодох Е010\_09 Үежиг Нолёж Ес9 Дөөрөөдөөнө Елн0 :  
 Дөөг | Нөөл 119 S 09 гөдө\* 10119 09 S0' 3 гөкөд КээКил | Фоллөөс0лээ  
 Монгодох Е010\_09 Үежиг Нолёж 09 Сид0л0лээ 0 Нолёг0л0лээ 0 Дилт 09  
 8' 1' 0 гөкөд 11р0лөөс' S8 гөдө\* 10119 09 S8' 2 гөкөд КээКил'  
 Монгодох Е010\_09 Үежиг Нолёж 09 Дөөг | Нөөл 119 8 гөдө\* 10119 09  
 Фоллөөдөө Дөөг |  
 ДөвН Нолёж 0 ВиллөөрКя 00 Фоллөөс11р0лээ  
 гөдө\* 00 Фоллөөрөөр0\* Нолээ  
 S0S1 Ф09 0 11 гөкө\* 26\*Т 119 1S- 09 Е00\*  
 Монгодох Е010\_09 Үежиг Нолёж 09 Дөөрөөдөг



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Авирмэдийн Баттөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Уламбаярын Нямхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Өлзийдэлгэрийн Батбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ганхуурайн Баттунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мижддоржийн Цэнгэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Жамбалдоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Нарантунгалагийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нямаагийн Наранбатыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдины Гансүхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зэнээмядарийн Батбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сайннямбуугийн Баатаржавыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Төмөрийн Лхагвадоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сосорбарамын Энхбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 10 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лодойдамбын Галбадрахыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жамсрангийн Бямбасүрэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 6 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2.4</sup>-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 261 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**А.АРИУНЗАЯА**

Засгийн газрын 2021 оны 172 дугаар  
тогтоолын хавсралт

### ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24-т заасан “Хүүхдийн төлөө сан” (цаашид “сан” гэх)-ийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сан нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.



## Хоёр.Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Сангийн удирдлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

2.2.Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

2.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ журмын 3.1.1-д заасан сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн, сонгон шалгаруулж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг байгуулж ажиллуулна.

2.4.Ажлын хэсэг нь холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, хүүхэд, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5.Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Ажлын хэсгийн гишүүдийн 75-аас дээш хувь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.6.Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, дүгнэлт гаргана.

2.7.Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадахгүйд хүрвэл энэ тухайгаа Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх бөгөөд бичгээр саналаа өгч болно.

2.8.Ажлын хэсгийн хуралдаанаас гаргах дүгнэлт нь тэмдэглэл хэлбэртэй байна. Тэмдэглэлд Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

2.9.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.9.1.санхүүжилт хүссэн төсөл, арга хэмжээний санал, хүсэлтийг энэ журамд заасан хугацаанд хүлээн авах;

2.9.2.тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, түүнд зарцуулах төсвийн саналыг боловсруулах, шийдвэрлүүлэх;

2.9.3.Ажлын хэсгийн хуралдааны зохион байгуулалтыг хангаж, асуудлыг хэлэлцүүлэх;

2.9.4.энэ журмын 3.1.1-д заасан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжихтэй холбогдуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан шийдвэрийн дагуу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээдтэй гэрээ байгуулан ажиллах, гүйцэтгэлийг хангуулах;

2.9.5.энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан шагнал урамшуулал, дэмжлэгийг үзүүлэхтэй холбогдуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

2.9.6.шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах, хөндлөнгийн дүгнэлт гаргуулах асуудлаар гэрээ хэлцэл хийх;

2.9.7.гадаад улс, олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандивын хөрөнгийг сангийн дансанд төвлөрүүлэх;

2.9.8.сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтын талаар олон нийтэд мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, сангийн мэдээллийн цахим хуудас ажиллуулах;

2.9.9.баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих.

Гурав.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ

3.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3-т заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

3.1.1.хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих;

3.1.2.олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;

3.1.3.олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх.



Дөрөв.Сангийн хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулах

4.1.Сангийн хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төслийн саналыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-аас 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр ирүүлнэ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан хугацаанаас бусад үед төслийн санал хүлээн авахгүй.

4.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 4.4-т заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ.

4.4.Энэ журмын 4.1-д заасан төслийн санал нь дараах шаардлагыг хангасан байна:

4.4.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3.1, энэ журмын 3.1.1-д заасан зориулалтын дагуу байх;

4.4.2.санхүүжилтээр дэмжих төсөл бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг хамт ирүүлсэн байх;

4.4.3.хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;

4.4.4.төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хүний нөөц, санхүүгийн эх үүсвэрийн тооцоо, судалгаа хийсэн байх;

4.4.5.байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх;

4.4.6.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт нийцсэн байх;

4.4.7.Сангийн сайдын баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцсэн байх.

4.5. Сангийн хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төслийг сонгон шалгаруулах талаар дараах арга хэмжээ авна:

4.5.1. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төслийн санал хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 14 хоногт багтаан Ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулна;

4.5.2. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн төсөл, арга хэмжээний талаар холбогдох этгээдээс нэмэлт мэдээлэл авч болно;

4.5.3. шаардлагатай гэж үзвэл санал ирүүлсэн иргэн, хуулийн этгээдээр Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулга хийлгэж болно;

4.5.4. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.6-д заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.1-д нийцүүлэн төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргана;

4.5.5. төсвийн жил дамжин хэрэгжихээс бусад төсөл, арга хэмжээтэй холбогдуулж гаргасан Ажлын хэсгийн дүгнэлт, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчинтэй байна.

4.6. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь гүйцэтгэсэн ажлын төсвийн зарцуулалт, хүрсэн үр дүн, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, гүйцэтгэлийн нэгдсэн тайланг гэрээнд заасан хугацаанд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Тав. Сангийн хөрөнгөөр олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах

5.1. Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахад энэ журмын хавсралтад заасан олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадын жагсаалтыг баримтална:

5.1.1. энэ журмын хавсралтад заасан жагсаалт нь олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахаар Засгийн газраас

баталсан бусад журамд заасан жагсаалттай давхцаж байгаа тохиолдолд мөнгөн урамшууллыг аль нэг журамд зааснаар давхардуулахгүйгээр олгоно;

5.1.2.энэ журмын хавсралтад заасан жагсаалтад орсон соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад амжилттай оролцож медаль хүртсэн хүүхдэд дор дурдсан мөнгөн шагналын хэмжээнээс энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан хувиар тооцож олгоно:

№	Тэмцээн наадмын ангилал	Медалийн төрөл	Мөнгөн шагналын хэмжээ (сая.төг)
1.	Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, наадам	Алт	5.0
		Мөнгө	4.0
		Хүрэл	3.0
2.	Олон улсын тэмцээн	Алт	3.0
		Мөнгө	2.0
		Хүрэл	1.0

5.1.3.спортын наадам, тэмцээний жин, зай, төрөлд оролцогчдын тоо, өрсөлдөөний чанараас хамааран дор дурдсан хувиар мөнгөн шагнал олгоно: (оюуны спорт, олимпиадад оролцсон хүүхдийн тоог адилтган хамруулна.)

№	Тэмцээний ангилал	Жин, зай, төрөл тус бүрд оролцсон тамирчдын тоо		Олгох мөнгөн шагналын хувь
		Эрэгтэй	Эмэгтэй	
1.	Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, наадам	20-оос дээш	15-аас дээш	100
		10-19 хүртэл	8-14 хүртэл	60
		9-өөс доош	7-оос доош	30
2.	Олон улсын тэмцээн	20-оос дээш	15-аас дээш	100
		10-19 хүртэл	8-14 хүртэл	60
		9-өөс доош	7-оос доош	30

5.1.4.соёл, урлагийн наадам, уралдааны төрөлд оролцсон оролцогчдын тоо, өрсөлдөөний чанараас хамааран дор дурдсан хувиар мөнгөн шагнал олгоно:



№	Уралдааны ангилал	Төрөл тус бүрд оролцогчдын тоо	Олгох мөнгөн шагналын хувь
1.	Тив, дэлхийн тэмцээн	20-оос дээш	100
		10-19 хүртэл	60
		9-өөс доош	30
2.	Олон улсын тэмцээн	15-аас дээш	100
		8-14 хүртэл	60
		7-оос доош	30

5.1.5.багийн төрөлд медаль хүртсэн багийн гишүүн тус бүрийн уралдаан тэмцээн, наадмын оролцооны статистикийг харгалзан дор дурдсан хувиар тооцож мөнгөн шагнал олгоно:

Оролцогч	Нийт оролцоонд хамаарах хувь	Олгох мөнгөн шагнал хувь
Багийн гишүүн	50 буюу түүнээс дээш хувь	100
	50 хүртэл хувь	50

5.1.6.шатрын сурагчдын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, Дэлхийн шатрын олимпиадыг Азийн аварга шалгаруулах тэмцээнтэй адилтган мөнгөн шагнал олгоно;

5.1.7.тухайн уралдаан тэмцээн нь тамирчдын нийлбэр дүнгээр амжилтыг тооцож медаль олгодог бол зөвхөн нийлбэр дүнгийн медалийн төрөлд мөнгөн шагнал олгоно.

5.2.Энэ журамд заасан мөнгөн шагналын болзол хангасан хүүхдийн харьяалах байгууллага, мэргэжлийн холбоо нь тэмцээн дууссанаас хойш 30 хоногт багтаан дараах материалыг бүрдүүлэн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлтээ ирүүлнэ:

5.2.1.шагнал урамшуулал авах хүсэлт;

5.2.2.хүүхдийн төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;

5.2.3.амжилтыг гэрчилсэн дипломын хуулбар, тэмцээн, наадамд амжилт гаргасныг нотолсон албан ёсны протоколыг байршуулсан цахим хаяг;

5.2.4.мөнгөн шагналыг шилжүүлэх банкны нэр, дансны дугаар, хүлээн авагчийн нэр, регистрийн дугаар.

5.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.2-т заасан материалыг нягтлан шалгаж, шаардлага хангасан хүсэлтийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэр гаргуулна.

5.4.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.1.2-т заасан мөнгөн шагналыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс гаргасан шийдвэрийн дагуу дараа сард багтаан олгоно.

Зургаа.Сангийн хөрөнгөөр олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх

6.1.Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.

6.2.Энэ журмын 6.1-д заасан дэмжлэг нь дараах төрөлтэй байна:

6.2.1.бэлтгэл хийх заал, байрны түрээсийн зардал;

6.2.2.шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал;

6.2.3.замын зардал;

6.2.4.тэмцээний хураамж;

6.2.5.олон улсад хүчинтэй эрүүл мэнд, гэнэтийн ослын

даатгалын хураамж;

6.2.6.хувцас хэрэгсэл.

6.3.Энэ журмын 6.2-т заасан дэмжлэгийг дараах хувь, хэмжээгээр тооцож олгоно:

6.3.1.энэ журмын 6.2.3, 6.2.4-т заасан зардал, хураамжийг 100 хувь;

6.3.2.энэ журмын 6.3.1-д зааснаас бусад төрлийн дэмжлэгийн нэг хүүхдэд ногдох нийт зардлын дээд хэмжээ 2.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

6.4.Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн харьяалах байгууллага, мэргэжлийн холбоо нь тэмцээн зохион байгуулагдах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дараах материалыг бүрдүүлэн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлтээ ирүүлнэ:



6.4.1.дэмжлэг авах хүсэлт;  
6.4.2.уралдаан тэмцээний албан ёсны урилга, заавар, тухайн тэмцээний мэдээллийг байршуулсан албан ёсны цахим хаяг;

6.4.3.оролцогч хүүхдийн төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;

6.4.4.шаардагдах зардлын тооцоо. (захиалгын хуудас, нэхэмжлэх, гэрээ)

6.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.4-т заасан материалыг нягтлан шалгаж, шаардлага хангасан хүсэлтийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэр гаргуулна.

6.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.2-т заасан дэмжлэгийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гарснаас хойш 14 хоногт багтаан олгоно.

#### Долоо.Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

7.1.Сангийн хөрөнгийн зарцуулалтад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

7.2.Сангийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцалж, үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй бөгөөд зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгийг эргэн төлүүлэх арга хэмжээ авна.

7.3.Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

7.4.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлт, тайлан гарснаас хойш 14 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

7.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гарган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сар бүрийн 4-ний өдрийн дотор харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүргүүлнэ.

7.7.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

### Найм.Бусад

8.1.Сангийн талаар дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүйгээр иргэн, хуулийн этгээдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа явуулах;

8.1.2.сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, баталгаа гаргах;

8.1.3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3-т заасан арга хэмжээнээс бусад арга хэмжээнд дэмжлэг, урамшуулал, тусламж, хандив олгох.

8.2.Энэ журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэж бүрдүүлсэн бол учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын хавсралт

### ОЛОН УЛС, ТИВ, ДЭЛХИЙН СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН, НААДАМ, ОЛИМПИАДЫН ЖАГСААЛТ

№	Ангилал		Оноосон нэр
1.	Олон улс, тив, дэлхийн спортын уралдаан тэмцээн	Азийн тивийн аваргын спортын төрөл	Азийн тивийн аварга
		Ази тивийн шатрын аварга	Шатрын сурагчдын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)
			Шатрын Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)
	Дэлхийн шатрын олимпиад	Дэлхийн шатрын олимпиад (14-өөс доош насны ангилал, баг 3 хүний бүрэлдэхүүнтэй)	



		<p>Тусгай Олимп, Дифлимп, Паралимп</p>	<p>Олон улсын Паралимпийн хороо, Олон улсын Дифлимпийн хороо, Олон улсын Тусгай Олимпийн хорооны ивээл дор зохион байгуулагдаж буй олон улс, бүс, өвөл, зуны спортын уралдаан тэмцээн, наадам</p>
		<p>Оюун ухааны спортын олон улс, тив, дэлхийн тэмцээн</p>	<p>Ой тогтоолтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (2 жилд 1 удаа)</p> <p>“Memoriad” World Mental Olympics буюу Оюуны олимп (4 жилд 1 удаа)</p> <p>Ой тогтоолтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)</p> <p>Ой тогтоолтын нээлттэй олон улсын тэмцээн (жилд 1 удаа)</p> <p>Олон улсын спорт өрөлтийн нээлттэй тэмцээн (жилд 1 удаа)</p> <p>Дэлхийн спорт өрөлтийн холбооны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа) Төрөл: “Ганцаарчилсан” буюу “3-3-3”, “3-4-3”, “Цикл”</p> <p>Дэлхийн спорт өрөлтийн холбооны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)</p> <p>Рубик шооны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)</p> <p>Рубик шооны Азийн аварга (жилд 1 удаа)</p> <p>Түргэн бодолтын олон улсын аварга шалгаруулах тэмцээн</p> <p>UCMAS олон улсын уралдаан соробан сампин, цээж тооллын олон улсын тэмцээн (жилд 1 удаа)</p>
<p>2.</p>	<p>Олон улс, тив, дэлхийн соёл, урлагийн уралдаан тэмцээн</p>	<p>Уран зураг</p>	<p>БНСУ-д зохион байгуулагддаг Зүүн хойд засаг захиргаадын “NEAR” олон улсын хүүхдийн уран зургийн уралдаан (жилд 1 удаа)</p> <p>БНХАУ-д зохион байгуулагддаг “Цайны зам” олон улсын Уран бичлэгийн уралдаан</p>

		Хөгжим	Итали, Римини “Олон улсын хөгжимчдийн уралдаан
			Итали Улс “Аргентогийн нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан”
			Чех Улс, Усти над Лабем хотноо зохиогддог “Виртуозы фотрерианной музыки” өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан
			Америкийн Нэгдсэн Улс, Нью-Йорк хотноо зохиогддог “Кришендо” өсвөрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
			Франц Улсад зохиогддог “Фламе” өсвөрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
			Итали Улсад зохиогддог “Барток-Кабалевский- Прокофьев”-ын нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан
			Чех Улсад зохиогддог Б.Сметаны нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан
			Япон Улсад зохион байгуулагддаг залуу хийлчдийн олон улсын уралдаан (жилд 1 удаа)
			Чех Улсад зохиогддог Хираны нэрэмжит өсвөрийн морин хийлчдийн олон улсын уралдаан
			Бельги Улсад зохиогддог А.Грумаксийн нэрэмжит өсвөрийн хийлчдийн олон улсын уралдаан
			ОХУ, “Сибирские музыкальные ассамблеи” Өсвөрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
		ОХУ, “Drum time” өсвөрийн цохивор хөгжимчдийн олон улсын уралдаан	
		Цирк	ОХУ-ын Никулиний циркээс зохион байгуулдаг Олон улсын циркчдийн тэмцээн (хүүхдийн төрөл жилд 1 удаа)
			Австралийн олон улсын циркчдийн фестиваль (хүүхдийн төрөл жилд 1 удаа)



3.	Олон улс, тивийн олимпиад	Олон улсын олимпиад	Математик
			Биологи
			Газар зүй
			Физик
			Мэдээлэл зүй
			Хими
			Менделеевийн олон улсын химийн олимпиад
		Тивийн олимпиад	Азийн физикийн олимпиад
			Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл зүйн олимпиад

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1, 11.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын виз олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Х.НЯМБААТАР**

Засгийн газрын 2021 оны 192 дугаар  
тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-д Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох, тус улсад байх визийн хугацааг сунгах, визийг хүчингүй болгохтой холбогдсон харилцаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

1.3.Харилцан адил байх зарчмыг баримтлан виз олгох нөхцөлийг өөрчилж болно.

1.4.Халдварт цар тахал, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор бүх төрлийн виз, визийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг виз олгох эрх бүхий байгууллагаас түдгэлзүүлж болно.

### Хоёр.Визийн ангилал

2.1.Дипломат, албан ангиллын визийг дараах гадаадын иргэнд олгоно:

2.1.1.“D” ангиллын визийг дипломат паспорттай гадаадын иргэн, улаан өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын ажилтан, албан тушаалтанд;

2.1.2.“D-1” ангиллын визийг дипломат паспорттай гадаадын иргэн, улаан өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын ажилтан, албан тушаалтны хамаарал бүхий этгээдэд;

2.1.3.“A1” ангиллын визийг албан паспорттай бөгөөд албан хэргээр зорчих гадаадын иргэн, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газрын шугамаар ирэх албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, цэнхэр өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан, албан тушаалтанд;



2.1.4.“А1-1” ангиллын визийг албан паспорттай бөгөөд албан хэргээр зорчих гадаадын иргэн, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газрын шугамаар ирэх албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, цэнхэр өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан, албан тушаалтны хамаарал бүхий этгээдэд;

2.1.5.“А2” ангиллын визийг гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтанд;

2.1.6.“А2-1” ангиллын визийг гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтны хамаарал бүхий этгээдэд;

2.1.7.“А3” ангиллын визийг Засгийн газар хоорондын, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэнд;

2.1.8.“А3-1” ангиллын визийг Засгийн газар хоорондын, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд.

2.2.Хөрөнгө оруулагчийн ангиллын визийг дараах гадаадын иргэнд олгоно:

2.2.1.“В1” ангиллын визийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчид;

2.2.2.“В1-1” ангиллын визийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн хамаарал бүхий этгээдэд;

2.2.3.“В2” ангиллын визийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэнд;

2.2.4.“В2-1” ангиллын визийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.2.5.“В3” ангиллын визийг гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэнд;

2.2.6. “B3-1” ангиллын визийг гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд.

2.3. Хөдөлмөр эрхлэх зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.3.1. “C1” ангиллын визийг барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.2. “C1-1” ангиллын визийг барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.3. “C2” ангиллын визийг шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.4. “C2-1” ангиллын визийг шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.5. “C3” ангиллын визийг геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.6. “C3-1” ангиллын визийг геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.7. “C4” ангиллын визийг санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.8. “C4-1” ангиллын визийг санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.9. “C5” ангиллын визийг соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.10. “C5-1” ангиллын визийг соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.11. “C6” ангиллын визийг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;





2.3.12.“С6-1” ангиллын визийг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.13.“С7” ангиллын визийг хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.14.“С7-1” ангиллын визийг хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.15.“С8” ангиллын визийг эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.16.“С8-1” ангиллын визийг эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.17.“С9” ангиллын визийг хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.18.“С9-1” ангиллын визийг хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.3.19.“С10” ангиллын визийг өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр ажиллахаар ирэх гадаадын иргэнд;

2.3.20.“С11” ангиллын визийг тээврийн салбарт ажиллах болон экспортын ачаа тээвэрлэх гадаадын иргэнд.

2.4.Суралцах зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.4.1.“Е1” ангиллын визийг ерөнхий боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэнд;

2.4.2.“Е2” ангиллын визийг дээд боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэнд;

2.4.3.“Е2-1” ангиллын визийг дээд боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.4.4.“Е3” ангиллын визийг монгол хэл, түүх, соёлын болон бусад чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэнд;

2.4.5. “E4” ангиллын визийг төрийн өмчит хуулийн этгээд болон эрдэм шинжилгээний байгууллагад дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэнд;

2.4.6. “E5” ангиллын визийг инновацийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэнд;

2.4.7. “E5-1” ангиллын визийг инновацийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд.

2.5. Гэр бүлийн зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.5.1. “F1” ангиллын визийг Монгол Улсын иргэнтэй гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэнд;

Тайлбар: Монгол Улсын иргэнтэй гэрлэлтээ Монгол Улсын, эсхүл гадаад улсын иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн гадаадын иргэнийг ойлгоно.

2.5.2. “F1-1” ангиллын визийг Монгол Улсын иргэнтэй гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдэд;

2.5.3. “F2” ангиллын визийг Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэнд;

2.5.4. “F2-1” ангиллын визийг Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.5.5. “F3” ангиллын визийг Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэнд;

2.5.6. “F3-1” ангиллын визийг Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд.

2.6. Цагаачлах зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.6.1. “G” ангиллын визийг цагаачид;

2.6.2. “G-1” ангиллын визийг цагаачийн хамаарал бүхий этгээдэд.



2.7.Хувийн зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.7.1.“Н1” ангиллын визийг Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэнд;

2.7.2.“Н1-1” ангиллын визийг Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.7.3.“Н2” ангиллын визийг Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэнд;

2.7.4.“Н2-1” ангиллын визийг Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэний хамаарал бүхий этгээдэд;

2.7.5.“Н3” ангиллын визийг хувийн бусад зорилгоор буюу энэ журмын 2.1-2.6, 2.7.1-2.7.4, 2.8, 2.9-д зааснаас бусад зорилгоор ирэх гадаадын иргэнд.

2.8.Шашны зорилгоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.8.1.“J” ангиллын визийг шашны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ирэх гадаадын иргэнд;

2.8.2.“J-1” ангиллын визийг шашны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд.

2.9.Түр ирэх гадаадын иргэнд дараах ангиллын виз олгоно:

2.9.1.“K1” ангиллын визийг ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэнд;

2.9.2.“K2” ангиллын визийг жуулчлах зорилгоор ирэх гадаадын иргэнд;

2.9.3.“K3” ангиллын визийг хил орчмын жуулчинд;

2.9.4.“K4” ангиллын визийг соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох, кино, контент бүтээхээр ирэх гадаадын иргэнд;



2.9.5. “К5” ангиллын визийг импортын ачаа болон зорчигч тээвэрлэх гадаадын иргэнд;

2.9.6. “К6” ангиллын визийг дамжин өнгөрөх гадаадын иргэнд;

2.9.7. “К7” ангиллын визийг Монгол Улсын олон улсын гэрээгээр тохиролцсоны дагуу харилцан адил нөхцөлөөр хөдөлмөр эрхлэх боломж бүхий богино хугацааны жуулчлалын хөтөлбөрт хамрагдан ирэх гадаадын иргэнд;

2.9.8. “К8” ангиллын визийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар ирэх гадаадын иргэнд.

Гурав.Виз, визийн зориулалт, төрөл, хугацаа

3.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.5-д заасан зориулалтын визийг дараах гадаадын иргэнд олгоно:

3.1.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.4-5.1.6-д заасан гадаадын иргэнд “орох”;

3.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнд “дамжин өнгөрөх”.

3.2.“Визийн хүчинтэй хугацаа” гэдэгт орох, дамжин өнгөрөх бүх төрлийн виз олгосон өдрөөс Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэлх хугацааг ойлгоно. Энэ нь дараах хугацаатай байна:

3.2.1.нэг болон хоёр удаагийн “орох”, “дамжин өнгөрөх” виз 150 хоног;

3.2.2.олон удаагийн виз 183 эсхүл 365 хоног.

3.3.Виз дээр бичигдсэн “байх хугацаа” нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш тус улсад байх хугацааг заах бөгөөд дараах хугацаатай байна:

3.3.1.нэг болон хоёр удаагийн орох виз 90 хүртэл хоног;

3.3.2.олон удаагийн виз 30 хоног;

3.3.3.бүх төрлийн “дамжин өнгөрөх” виз 10 хүртэл хоног;

3.3.4.хил орчмын жуулчинд олгох өдрийн виз 3 хүртэл хоног;

3.3.5.албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний “орох” виз дээр байх хугацааг заахгүй.

3.4.Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх нийт хугацаа тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд тус улсад оршин суух зөвшөөрөл авна.

3.5.Визийн хүчинтэй хугацааг он, сар, өдөр гэсэн дарааллаар тэмдэглэнэ.

#### Дөрөв.Виз олгох байгууллагын бүрэн эрх

4.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын виз, визийн зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох.

4.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1.энэ журмын 2.1.7-2.9.8-д заасан ангиллын бүх төрлийн визийг олгох, олгохоос татгалзах, хугацааг сунгах, хүчингүй болгох, энэ журмын 2.9.2-т заасан 30 хүртэлх хоногийн нэг, хоёр удаагийн болон 2.9.3-т зааснаас бусад ангиллын бүх төрлийн визийн зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох;

4.2.2.тухайн ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа нөхцөлд энэ журмын 2.1.7-2.9.8-д заасан ангиллын орох, дамжин өнгөрөх визийг Монгол Улсын хилийн боомт дээр олгох;

4.2.3.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын визийг Монгол Улсын хилийн боомт дээр олгох.

4.3.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар нь виз олгох талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын визийг олгох;

4.3.2.энэ журмын 2.9.2-т заасан ангиллын 30 хүртэлх хоногийн нэг, хоёр удаагийн болон 2.9.3-т заасан ангиллын визийг олгох;

4.3.3.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу энэ журмын 4.3.1, 4.3.2-т зааснаас бусад визийг олгох;

4.3.4.Монгол Улсыг хавсран суугаа болон гадаад улсын бусад Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөний ноот бичгийг үндэслэн гадаадын иргэнд 2.1.1-2.1.6-т заасан ангиллын визийг олгох.

4.4.Виз олгох байгууллага нь энэ журмын 2.5.3, 2.5.5, 2.7.3-т заасан ангиллын нэг болон хоёр удаагийн “орох” зориулалтын 90 хүртэл хоногийн визийг зөвшөөрөлгүйгээр олгож болно.

#### Тав.Визийн зөвшөөрөл олгох

5.1.Визийн зөвшөөрөл нь олгогдсон өдрөөс хойш 60 хоногийн дотор хүчинтэй байна.

5.2.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын визийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

5.2.1.ноот, албан захидал зэрэг баримт бичиг;

5.2.2.гадаадын иргэний паспорт, паспортыг орлох баримт бичиг (цаашид “паспорт” гэх)-ийн хуулбар;

5.2.3.визийн мэдүүлгийн хуудас;

5.3.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ журмын 4.2.1-д заасан визийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

5.3.1.уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт;

5.3.2.гадаадын иргэний паспортын хуулбар;

5.3.3.хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах зорилгоор ирэх гадаадын иргэнд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;

5.3.4.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын гэрчилгээний хуулбар;

5.3.5.мэдүүлгийн хуудас.

5.4.Гадаадын иргэний хамаарал бүхий этгээд виз мэдүүлэхэд гэрлэлтийн, төрсний, үрчлэлтийн гэрчилгээ, лавлагаа зэрэг нотлох баримт бичгийг албан ёсны орчуулгын хамт бүрдүүлнэ.

5.5.Хөрөнгө оруулах зорилгоор визийн зөвшөөрөл мэдүүлэхэд гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын тодорхойлолт, визийн зөвшөөрөл мэдүүлэгчийн сүүлийн 6 сарын дансны хуулгыг бүрдүүлнэ.

5.6.Олон удаагийн виз, визийн зөвшөөрөл хүсэхэд энэ журмын 5.3-т зааснаас гадна уригч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, гаалийн бүрдүүлэлт, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт зэрэг хилийн боомтоор олон удаа нэвтрэх шаардлагатайг нотлох баримт бичгийг бүрдүүлнэ.

5.7.Визийн зөвшөөрлийг Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон хилийн боомт дахь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын салбар, нэгжид цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

5.8.Шаардлагатай тохиолдолд виз, визийн зөвшөөрөл олгохдоо тагнуул, цагдаагийн байгууллагын саналыг авах бөгөөд тухайн байгууллага нь саналаа ажлын 5 өдрийн дотор ирүүлнэ.

5.9.Виз, визийн зөвшөөрөл мэдүүлэгч, уригч дараах үүрэг хүлээнэ:

- 5.9.1.мэдүүлгийн үнэн зөвийг нотлох;
- 5.9.2.баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх;
- 5.9.3.шаардсан нэмэлт баримт бичгийг бүрдүүлэх.

#### Зургаа.Виз олгох

6.1.“Дамжин өнгөрөх” визийг тухайн гадаадын иргэний очих улсын виз, эсхүл тийзийг үндэслэн хилийн боомт дээр олгож болно.

6.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.8, 15.1-д заасан виз мэдүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- 6.2.1.паспорт;
- 6.2.2.3.5 см x 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;
- 6.2.3.мэдүүлгийн хуудас;
- 6.2.4.гадаадын иргэд бүлгээр аялах тохиолдолд эрх бүхий хүлээн авагчийн урилга болон илгээгч байгууллагын хүсэлт;
- 6.2.5.визийн хураамж төлсөн баримт.

6.3.Гадаадын иргэн нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, хилийн боомтод энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ангиллын виз мэдүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.3.1.паспорт;  
6.3.2.3.5 см х 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;  
6.3.3.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан бичиг, эсхүл визийн зөвшөөрөл.

6.3.4.мэдүүлгийн хуудас.

6.4.Энэ журмын 2.9.2-т заасан “K2” ангиллын 30 хүртэл хоногийн нэг болон хоёр удаагийн виз мэдүүлэгч нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, хилийн боомтод виз мэдүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.4.1.паспорт;  
6.4.2.3.5 см х 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;  
6.4.3.мэдүүлгийн хуудас;  
6.4.4.гадаадын иргэд бүлгээр аялах тохиолдолд эрх бүхий хүлээн авагчийн урилга болон илгээгч байгууллагын хүсэлт;

6.4.5.визийн хураамж төлсөн баримт;  
6.4.6.шаардлагатай тохиолдолд санхүүгийн чадавхтайг нотолсон баримт бичиг, ирэх, буцах тийз захиалгын хуудас.

6.5.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, хилийн боомтод энэ журмын 6.3, 6.4-т зааснаас бусад ангиллын виз мэдүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.5.1.паспорт;  
6.5.2.3.5 см х 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;  
6.5.3.мэдүүлгийн хуудас;  
6.5.4.виз олгох эрх бүхий байгууллагаас олгосон визийн зөвшөөрөл, хувийн урилга;

6.5.5.шаардлагатай бол албан хүсэлт;  
6.5.6.визийн хураамж төлсөн баримт.

6.6.Энэ журмын 2.9.3-т заасан ангиллын визийг Монгол Улсын хилийн тухай хуульд заасан хил орчмын нутаг дэвсгэр буюу хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрт жуулчлах гадаадын иргэнд олгоно.



6.7.Хил орчмын аялал жуулчлалаар ирэх бүлэг жуулчинд олгох “К3” ангиллын визийг ахлагчийн паспорт дээр, дагалдан зорчих гишүүдийн визийг жагсаалтаар буюу хавсралт хуудсаар олгож болно.

6.8.Энэ журмын 6.7-д заасан бүлэг жуулчны Монгол Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгсэл, маршрут, аяллын хөтөлбөр, ирэх, буцах хугацаа адил байна.

6.9.Энэ журмын 2.9.7-д заасан “К7” ангиллын виз олгохтой холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

6.10.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар нь энэ журмын 2.9.2-т заасан “К2” ангиллын 30 хүртэл хоногийн визийг олгохдоо холбогдох баримт бичгийг хүлээн авч виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг бүртгэн, хянаж, виз олгох эсэхийг шийдвэрлэнэ.

6.11.Олон улсын нислэгээр албан ажлаар ирж байгаа агаарын хөлгийн багаас 72 хүртэл цагийн хугацаатай нэвтрэхэд виз шаардахгүй.

6.12.Визийн мэдүүлгийг дараах албан тушаалтан хянан баталгаажуулснаар виз олгоно:

6.12.1.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал эрхэлсэн нэгжийн эрх бүхий албан тушаалтан;

6.12.2.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан;

6.12.3.гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, түүний эрх олгосон албан тушаалтан.

6.13.Хуудас дууссан, хүчингүй болсон, эсхүл гэмтээсэн зэргээр ашиглах боломжгүй болсон хүчин төгөлдөр визтэй паспортыг шинэ паспортын хамт авч яваа тохиолдолд визийг шилжүүлэхийг шаардахгүй.

6.14.Гадаадын иргэн хүсэлт гаргасан тохиолдолд визийг шинэ паспортад шилжүүлэн олгох бөгөөд зөвхөн визийн үйлчилгээний хөлс төлнө.

6.15.Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн гэрээнд зааснаас илүү хугацаагаар зорчих, оршин суух зөвшөөрөл хүсэх

тохиолдолд зохих ангиллын визийг урьдчилан авсан байна.

6.16.Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд хураамжийг буцаан олгохгүй.

#### Долоо.Цахим виз олгох

7.1.Энэ журмын 2.9.2, 2.9.4, 2.9.6-д заасан ангиллын визийг цахимаар олгож болно.

7.2.Цахимаар виз мэдүүлэгч нь визийн мэдүүлгийг бөглөн паспортын хуулбар, цээж зураг зэрэг шаардлагатай баримт бичгийг холбогдох системд оруулна.

7.3.Цахим визийн мэдүүлгийг 3 хүртэл хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

7.4.Цахим визийг олгохыг зөвшөөрсөн тохиолдолд овог нэр, төрсөн огноо, хүйс, паспортын дугаар, улсын харьяалал, бүртгэлийн дугаар, визийн дугаар, олгосон огноо, хүчинтэй огноо, ангилал, байх хугацаа зэрэг шаардлагатай мэдээлэл бүхий визийг виз мэдүүлэгчийн баталгаат цахим шууданд илгээнэ.

7.5.Цахим визийг олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай виз мэдүүлэгчийн баталгаат цахим шууданд хариуг илгээнэ.

7.6.Цахим визийн загварыг Олон улсын иргэний агаарын тээврийн холбоо, гадаад улсын болон олон улсын холбогдох байгууллагад бүртгүүлэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

#### Найм.Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах, хүчингүй болгох

8.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан болон дараах үндэслэлээр виз, визийн зөвшөөрлийг олгохоос татгалзана:

8.1.1.шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгөөгүй, баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь тогтоогдсон;

8.1.2.виз, визийн зөвшөөрөл олгох үндэслэл тогтоогдоогүй;

8.1.3.гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан үүргээ биелүүлээгүй;

8.1.4.эрх бүхий байгууллагын бичгээр ирүүлсэн саналыг харгалзан.

8.2.Виз, визийн зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

8.2.1.Монгол Улсад орохыг үл зөвшөөрсөн хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд;

8.2.2.уригчийн үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан;

8.2.3.эрх бүхий байгууллагын бичгээр ирүүлсэн саналыг харгалзан;

8.2.4.визийн хуудас засвартай, бичилт, тэмдэглэгээ алдаатай;

8.2.5.албадан гаргаж байгаа;

8.2.6.визийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй олгосон;

8.2.7.баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлж виз авсан нь тогтоогдсон;

8.2.8.гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн санал, дүгнэлт.

8.3.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн нь гадаадын иргэн, уригч, ажил олгогчид виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болно.

8.4.Визийг хүчингүй болгохдоо визийн хуудас дээр “хүчингүй” буюу “void” тэмдэг дарна.

8.5.Энэ журмын 8.1.1-д заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь тогтоогдсон болон 8.2.7-д заасан үндэслэлээр виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан, хүчингүй болгосон бол 180 хоног, бусад үндэслэлээр татгалзсан бол 30 хоногийн дараа хүсэлтээ дахин гаргаж болно.

8.6.Визийн мэдүүлгийг хянан үзээд виз олгохоос татгалзах тохиолдолд энэ тухай хариу мэдэгдэнэ.

8.7.Энэ журмын 8.2-т заасан үндэслэлээр визийг хүчингүй болгосон бол зохих ангиллын визийг дахин олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.

#### Ес.Монгол Улсад байх хугацааг сунгах

9.1.Түр ирэгч гадаадын иргэн Монгол Улсад байх хугацааг сунгуулах хүсэлтээ дараах баримт бичгийг бүрдүүлэн уг хугацаа дуусахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан эрх бүхий байгууллагад гаргана:

- 9.1.1.паспорт;
- 9.1.2.уригчтай бол уригчийн хүсэлт;
- 9.1.3.мэдүүлгийн хуудас.

9.2.Түр ирэгч гадаадын иргэний өмнөх сунгалтын хугацаа дууссанаас хойш 90 хоногийн дараа дахин сунгуулах хүсэлт гаргаж болно.

9.3.Төрийн болон Засгийн газар хоорондын байгууллагын шугамаар ирсэн гадаадын иргэний визийн хугацааг сунгахад энэ журмын 9.2 дахь хэсэг хамаарахгүй.

9.4.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчиж, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл хүлээсэн түр ирэгч гадаадын иргэний тухайн визийн байх хугацааг сунгахгүй.

9.5.Гадаадын иргэний баримт бичигт визийн сунгалт хийсэн өдрийг “Registered” (Бүртгэсэн), тус улсаас гарах эцсийн хугацааг заасан өдрийг “Until” (Хүртэл) тэмдэглэгээ бүхий тэмдэгт тэмдэглэнэ.

#### Арав.Бусад

10.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчиж Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл хүлээсэн гадаадын иргэний баримт бичигт тус улсаас гарах эцсийн хугацааг заахдаа энэ журмын 9.5-д заасан тэмдэгт тэмдэглэнэ.

10.2.Энэ журмын 10.1-д заасан тэмдэглэгээ нь шийтгэл оногдуулсан өдрөөс хойш 10 хүртэл хоногийн хугацаатай байна. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж Монгол Улсаас гарах үүрэгтэй.

10.3.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “Визийн мэдүүлгийн хуудас”, бүлэг жуулчинд олгох хавсралтын загвар, энэ журмын 8.4, 9.5-д заасан тэмдгийн загварыг тус

тус баталж, загварыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

10.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь виз, визийн зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг ажлын 5 хоногт, яаралтай бол ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

10.5.Виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхэд паспортын хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байна.

10.6.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.8-д заасан болон Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.7.Гадаадын иргэнийг шилжүүлэн ажиллуулж буюу суралцуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь уригчийн үүргийг хүлээнэ.

10.8.Энэ журмын 2.9.2-т заасан ангиллын визийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Монгол Улсын визийн төвөөр дамжуулан мэдүүлж болно.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

**Индекс:** 200003